



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХЭРЭМТ ЦАМХАГ УТУГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/92/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 99240882 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Энхжин
Утас: 99010342 Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн:
Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн
Захирал Г.Энхтөр
Утас: 80281690, 99032916 Цахим хаяг: ij17.audit@gmail.com

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	7
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
5.1 Шилэн дансны мэдээлэл	10
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	10
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
7. Аудитын илрүүлэлт	11
7.1 Залруулсан алдаа	11
7.2 Зөвлөмж	11
8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



ХЭРЭМТ ЦАМХАГ УТҮГ-ЫН ДАРГА,
ХУРАНДАА Н.МӨНХЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/544
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны А/50 дугаар тушаалаар Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2021 оны үйлдвэр, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 1,129.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 904.8 сая төгрөгөөр, ашгийг 224.4 сая төгрөг байхаар баталжээ. Гүйцэтгэлээр 1,158.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 908.8 сая төгрөгийн зардал гарган, 249.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2021 оны төлөвлөгөөнд 6000 куб/метр хөнгөн блок үйлдвэрлэхээр батлагдсан боловч тоног төхөөрөмжийг шинэчлэх нээлттэй тендер шалгаруулалтад санал ирээгүйгээс шинэчлэлт хийгдээгүй, 5364 куб/метр хөнгөн блок үйлдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах тухай” 02 тоот албан даалгаврын биелэлтийг хангах ажлын хүрээнд 4 бүлэг ажил гүйцэтгэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Д.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	74,007,996.93	690,466,600.58
1.1.2	Дансны авлага	272,404,764.40	27,786,598.62
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	2,722,280.66	2,930,560.82
1.1.4	Бусад авлага	62,468,800.00	2,714,080.00
1.1.5	Бараа материал	98,379,433.84	46,418,460.88
1.1.6	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	173,480,303.92	10,627,550.50
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	683,463,579.75	780,943,851.40
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	897,039,085.86	1,155,427,518.01
1.2.2	Биет бус хөрөнгө		180,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	897,039,085.86	1,155,607,518.01
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,580,502,665.61	1,936,551,369.41
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	577,000.00	
2.1.1.3	Татварын өр	1,912,456.37	8,012,239.26
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	45,195,000.00	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	47,684,456.37	8,012,239.26
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	47,684,456.37	8,012,239.26
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	161,096,688.93	161,096,688.93
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,837,618,783.49	2,162,858,493.49
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(465,897,263.18)	(395,416,052.27)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг / алдагдал /	(42,181,743.06)	37,625,079.53
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг / алдагдал /	(423,715,520.12)	(433,041,131.80)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,532,818,209.24	1,928,539,130.15
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,580,502,665.61	1,936,551,369.41

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,086,636,445.18	1,158,467,141.70
2	Борлуулалтын өртөг	954,125,213.06	908,791,298.84
3	Нийт ашиг(алдагдал)	132,511,232.12	249,675,842.86
4	Хүүний орлого	2,740,488.46	5,617,885.60
5	Бусад орлого	640,000.00	373,619.21
6	Борлуулалт, маркетингийн зардал	968,199.94	1,227,181.87
7	Ерөнхий ба удирдлагын зардал	81,792,124.04	101,523,410.74
8	Бусад ашиг (алдагдал)	(90,000,000.00)	(100,000,000.00)
9	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(36,868,603.40)	52,916,755.06
10	Орлогын татварын зардал	5,313,139.66	15,291,675.53
11	Татварын дараах ашиг (алдагдал)	(42,181,743.06)	37,625,079.53
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(42,181,743.06)	37,625,079.53
13	Орлогын нийт дүн	(42,181,743.06)	37,625,079.53
14	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	/төгрөгөөр/
				2021 оны 12-р сарын 31
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	161,096,688.93	1,837,618,783.49	(446,500,346.19)	1,552,215,126.23
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			22,784,826.07	22,784,826.07
Залруулсан үлдэгдэл	161,096,688.93	1,837,618,783.49	(423,715,520.12)	1,574,999,952.30
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(42,181,743.06)	(42,181,743.06)
2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	161,096,688.93	1,837,618,783.49	(465,897,263.18)	1,532,818,209.24
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			32,856,131.38	32,856,131.38
Залруулсан үлдэгдэл	161,096,688.93	1,837,618,783.49	(433,041,131.80)	1,565,674,340.62
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			37,625,079.53	37,625,079.53
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		325,239,710.00		325,239,710.00
2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	161,096,688.93	2,162,858,493.49	(395,416,052.27)	1,928,539,130.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	824,585,867.29	1,517,187,914.86
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	626,528,615.00	1,173,972,264.40
	Бусад мөнгөн орлого	198,057,252.29	343,215,650.46
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	905,303,955.38	806,347,196.81
	Ажиллагчдад төлсөн	205,911,185.12	212,656,102.28
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,299,014.87	4,085,516.05
	Бараа материал худалдан авахад төлсөн	354,568,711.89	317,967,022.50
	Ашиглалтын зардалд төлсөн	132,355,406.61	28,908,879.62
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	73,929,970.00	54,707,614.00
	Бусад мөнгөн зарлага	134,239,666.89	188,022,062.36
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(80,718,088.09)	710,840,718.05
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,740,488.46	5,617,885.60
	Хүлээн авсан хүүний орлого	2,740,488.46	5,617,885.60
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,740,488.46	5,617,885.60
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	26,551,500.00	100,000,000.00
	Бусад	26,551,500.00	100,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(26,551,500.00)	(100,000,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(104,529,099.63)	616,458,603.65
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	178,537,096.56	74,007,996.93
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	74,007,996.93	690,466,600.58

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Борлуулалтын орлого (цэвэр)	мян.төг	1,086,636.4	940,000.0	1,158,467.2	218,467.2	123.2
2	Борлуулалтын өртөг	мян.төг	954,125.2	904,714.0	908,791.3	4,077.3	100.5
3	Нийт ашиг(алдагдал)	мян.төг	132,511.2	35,286.0	249,675.9	214,389.9	707.6
4	Хүүний орлого	мян.төг	2,740.5	-	5,617.9	5,617.9	
5	Бусад орлого	мян.төг	640.0	189,240.8	373.6	(188,867.2)	0.2
6	Борлуулалт, маркетингийн зардал	мян.төг	968.2	-	-	-	
7	Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	81,792.1	-	102,750.6	102,750.6	
8	Бусад ашиг (алдагдал)	мян.төг	(90,000.0)	-	(100,000.0)	(100,000.0)	
9	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	мян.төг	(36,868.6)	224,526.8	52,916.8	(171,610.0)	23.6
10	Орлогын татварын зардал	мян.төг	5,313.1				
11	Татвар дараах ашиг(алдагдал)	мян.төг	(42,181.7)	224,526.8	52,916.8	(171,610.0)	23.6

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өглөг, авлагатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 21-ээс 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн Ахлах аудитор Э.Батчимэг, аудитор Ч.Минжүүр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Г.Энхтөр хэрэгжүүлсэн.

Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 01/37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 1,090.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 10.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хэрэмт цамхаг УТҮГ-ын зорилго нь эрхэлсэн үйлдвэрлэл, ажил үйлчилгээндээ ялтныг хөдөлмөрлүүлж, тэдэнд хөдөлмөрийн дадлага мэргэжлийн баримжаа олгон, улмаар тэднээс төр хуулийн этгээд, иргэнд шүүхийн шийдвэрээр нөхөн төлүүлэх төлбөрийг барагдуулахад дэмжлэг үзүүлэх, тэднийг хүмүүжүүлэх болон хуулийн хэрэгжилтийг хангуулахад оршино.

Хэрэмт цамхаг УТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ШШГЕГ-аас баталсан төлөвлөгөөний дагуу барилгын материал үйлдвэрлэж, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжид хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх;
- Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа хуулийн этгээдэд Ерөнхий газраас тогтоосон тарифын дагуу барилгын материал үйлдвэрлэн нийлүүлэх;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, ажилтан, бусад захиалагчийн хэрэгцээнд чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг худалдан борлуулах;
- Техник, технологийн дэвшил нэвтрүүлэх, тоног төхөөрөмж туршин нэвтрүүлэх, зохион бүтээх, шинэ бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох;
- Хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр буюу ШШГЕГ 100 хувь эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хэрэмт цамхаг УТҮГ-ыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2007 оны А/30 дугаар тушаалыг үндэслэн байгуулсан байна. ШШГЕГ-ын даргын 2017 оны А/256 тоот тушаалаар УТҮГ-ын дүрмийг өөрчлөн баталсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т заасны дагуу цалин хөлсийг нэмэгдүүлэхгүйгээр дотоод зохион байгуулалтын бүтцийг хэвээр хадгалж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хэрэмт цамхаг УТҮГ санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	74,008.0	690,466.6	616,458.6
Авлага	337,595.9	33,431.2	(304,164.7)
Бараа материал	98,379.4	46,418.5	(51,960.9)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	173,480.3	10,627.5	(162,852.8)
Үндсэн хөрөнгө	897,039.1	1,155,427.5	258,388.4
Биет бус хөрөнгө	-	180.0	180.0
Нийт хөрөнгийн дүн	1,580,502.7	1,936,551.3	356,048.6
Богино хугацаат өглөг	47,684.5	8,012.2	(39,672.3)
Эздийн өмч	1,532,818.2	1,928,539.1	395,720.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,580,502.7	1,936,551.3	356,048.6

Арилжааны банкны харилцах дансанд 690.5 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд татварын байгууллагаас авах 2.9 сая, харилцагч байгууллагаас авах 27.8 сая, хувь хүнээс авах 2.7 сая төгрөгийн авлага байна.

Тайлант онд үйл ажиллагааны хүрээнд үүссэн 1,370.6 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж, өмнөх оны 244.6 сая авлагыг барагдуулжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 8.8 сая төгрөг, хугацаа хэтэрсэн 2017-2018 онд үүссэн 24.6 сая төгрөгийн авлага байна. Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах шүүхийн шийдвэр гарсан боловч авлагын барагдалт удаашралтай байгаа тул Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт албан бичиг хүргүүлсэн байна.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө Баянзүрх дүүргийн 10 дугаар хороонд байршилтай “ЦЭЭБ” ХХК-ийн “Цагдаа хотхон”-оос авсан 4 орон сууц, 1 авто зогсоолыг борлуулснаас 162.8 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дуусаагүй барилга, их засварын зардал 3.9 сая, хөрөнгийн дахин үнэлгээ 325.0 сая, аж ахуйн материал данснаас шилжүүлсэн 15.4 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 576 тоот тогтоолоор акталсан 73.4 сая төгрөгийн хөрөнгийн дүн болон дахин үнэлгээний бууралт 325.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд НӨАТ-ын өглөг 8.0 сая төгрөгийн өр төлбөр байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааран зардал гэж хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад ерөнхий удирдлагын зардал 19.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дулааны шугам сүлжээнд урсгал засварын ажил хийгдсэнээс шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хэрэмт цамхаг УТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ШШГЕГ-ын даргын 2021 оны А/50 дугаар тушаалаар Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2021 оны үйлдвэр, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 1,129.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 904.8 сая төгрөгөөр, ашгийг 224.4 сая төгрөг байхаар баталжээ.

Гүйцэтгэлээр 1,158.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 908.8 сая төгрөгийн зардал гарган, 249.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Тайлант онд цэвэр ашиг 249.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 25.3 сая төгрөгөөр давсан нь борлуулалтын тоо хэмжээ өсөлт нөлөөлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд нийт 4,150.0 сая төгрөгийн 198 ажил гүйлгээний мэдээллийг ил тод байршуулахаас 84.5 сая төгрөгийн 8 ажил гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1 мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; ...4.1.3 тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; ...”, 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: ... 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр...” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн "Дүрэм батлах тухай" А/256 дугаар тушаалаар 2007 оны А/30 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан дүрмийг хүчингүй болгож, Хэрэмт цамхаг УТҮГ-ын дүрмийг 5 дугаар хавсралтаар өөрчлөн баталсан байна. Дүрмийн 1.3 "Хэрэмт цамхаг УТҮГ-нь улсын төсөв болон дотоод орлогоос санхүүжнэ. Төсвийн болон үйлдвэрлэлийн гэсэн бие даасан хоёр данс, тайлан тэнцэлтэй байгууллага мөн" гэж заасан нь улсын бүртгэлийн нэг гэрчилгээ, дүрэмтэй 2 байгууллага байхаар тусгасан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9-р зүйлийн 9.5-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах эрхтэй байна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15-р зүйлийн 3-т "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үдсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн

хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ" гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.3 "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4 "үнэн зөв байх", 5.1.5 "хэмжигдэхүйц байх" 5.1.6 "зохицох" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжийн дагуу дүрэмд өөрчлөлт оруулах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, байгууллагын дүрэмд оруулсан өөрчлөлт нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 229.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 133.4 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 96.3 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 132.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 3 зөрчилд зөвлөмж өгснөөс акт албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1.5	1	1.5	-	-	100.0
Албан шаардлага	1	1,322.4	1	1,322.4	-	-	100.0
Зөвлөмж	3	-	3	-	-	-	100.0
Дүн	5	1,323.9	5	1,323.9	-	-	100.0

/мянган төгрөг/

7. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 327.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 325.5 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 2.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 2.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 10.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Зөрчилгүй" дүгнэлт өглөө.

7.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 325.5 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- ТӨБЗГ-ын 2021 оны 701 дүгээр тогтоолын дагуу үнэлсэн 325.2 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг бусад орлогоор бүртгэснийг залруулж, дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэсэн.
- Нэр бүхий 3 ажилтны ээлжийн амралтын олговор тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо унаа, хоолны хөнгөлөлтийг оруулж 0.3 сая төгрөг илүү тооцон олгосныг залруулсан.

7.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Татвартай холбоотой асуудал**Илрүүлэлт:**

Санхүүгийн тайлангаарх ХХОАТ-ын өглөгийг татварын цахим систем дэх “Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар”-ын тайлангийн өглөгөөс 2.0 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “Суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 “Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ” гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын байгууллагад суутган татвар ногдуулалт, төлөлтийг зөв тайлагнаж, улирал бүр авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/мянган төгрөгөөр/												
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн асуудлаар																	
1	Хэрэмт цамхаг УТҮГ	АХГ-2022/92/НА-СТА-ТӨА	Тухайн байгууллагын тайлант хугацааны нягтлан бодох бүртгэлийн журналын гүйлгээг татварын ТТ-11 тайлантай тулган шалгахад 2,037.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "Суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27-р зүйлийн 27.1 "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн	1	2,037.6									1	2,037.6	
2	Хэрэмт цамхаг УТҮГ	АХГ-2022/92/НА-СТА-ТӨА	Нэр бүхий 3 ажилтны ээлжийн амралтын олговор тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо унаа, хоолны хөнгөлөлтийг оруулж илүү тооцон олгосон байна.	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 тоот тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 4 "Ажилтанд олгож байгаа бүр төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа,	1	296.6	1	296.6									

				түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй"																
3	Хэрэмт цамхаг УТҮГ	АХГ-2022/92/НА-СТА-ТӨА	ТӨБЗГ-ын 2021 оны 12-р сарын 30-ны 701 тоот тогтоолоор 38 нэр төрлийн 107 ширхэг хөрөнгийг дахин үнэлсэн бөгөөд дахин үнэлгээний нэмэгдлийг бусад орлогоор бүртгэсэн байна.	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг НББОУС-16 үндсэн хөрөнгө 39-р параграфын дагуу дахин үнэлгээний нэмэгдэл дансанд өмчийн хэсэгт бүртгэнэ	1	325,239.7	1	325,239.7												
ДҮН					3	327,573.9	2	325,536.3										1	2,037.6	
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																				
1	Хэрэмт цамхаг УТҮГ	АХГ-2022/92/НА-СТА-ТӨА	Тайлант онд Шилэн дансны цахим мэдээллийг 98 хувийн гүйцэтгэлтэй ил тод мэдээлсэн бөгөөд 84,508.3 мянган төгрөгийн 8 мэдээллийг мэдээлээгүй байна.	Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ"	1	84,508.3											1	84,508.3		
2	Хэрэмт цамхаг УТҮГ	АХГ-2022/92/НА-СТА-ТӨА	ШШГЕГ-ын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн "Дүрэм батлах тухай" А/256 тоот тушаалаар 2007 оны 2-р сарын 23-ны өдрийн А/30 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан дүрмийг хүчингүй болгож, Хэрэмт цамхаг УТҮГ-ын дүрмийг 5-р хавсралтаар өөрчлөн баталсан байна. Дээрх тушаал нь ТӨБЗГ-аас зөвшөөрөл аваагүй, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8-р зүйлийн 8.4, 262-р зүйлийн 262.1.2 дахь заалт, ШШГЕГ-ын даргын зөвлөлийн 2017 оны 12-р сарын 5-ны өдрийн 21-р хуралдааны шийдвэрийг үндэслэл болгосон нь холбогдох хуульд нийцэхгүй байна. Өөрчлөн баталсан дүрмийн 1.3-т "Хэрэмт цамхаг" УТҮГ-нь улсын төсөв болон дотоод орлогоос санхүүжнэ.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9-р зүйлийн 9.5-д зааснаар Засгийн газар нь хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах эрхтэй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15-р зүйлийн 3 "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үдсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлвэрийн газар гэнэ" гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.3 "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4 "үнэн зөв байх", 5.1.5 "хэмжигдэхүйц байх" 5.1.6	1	-												1	-	

			Төсвийн болон үйлдвэрлэлийн гэсэн бие даасан хоёр данс, тайлан тэнцэлтэй байгууллага мөн" гэж заасан нь улсын бүртгэлийн нэг гэрчилгээ, дүрэмтэй 2 байгууллага болгосон байна.	"зохицох" зарчмуудтай нийцэхгүй байна.												
			ДҮН		2	84,508.3					2	84,508.3				
			НИЙТ ДҮН		5	412,082.2	2	325,536.3			2	84,508.3			1	2,037.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 358/АД150055

Улаанбаатар хот

АТ-2022/02/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд 84,508,300.00 төгрөгийн 8 ажил гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1 .мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”; 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”, 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”; 6.4.5. “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг ил тод, хугацаанд нь бүрэн байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрэмт цамхаг УТҮГ-ын дарга, хурандаа Н.Мөнхжаргал, нягтлан бодогч Т.Чулуунцэнд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Г.ЭНХТӨР

9006109
9019120396

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0315 Auditin 2 Газар-39.Docx

0010801051



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 359/АО150055

Улаанбаатар хот

АХТ-2022/92/НА-СТА-ТНЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн "Дүрэм батлах тухай" А/256 дугаар тушаалаар 2007 оны А/30 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан дүрмийг хүчингүй болгож, Хэрэмт цамхаг УТҮГ-ын дүрмийг 5 дугаар хавсралтаар өөрчлөн баталсан байна. Дүрмийн 1.3 "Хэрэмт цамхаг УТҮГ-нь улсын төсөв болон дотоод орлогоос санхүүжнэ. Төсвийн болон үйлдвэрлэлийн гэсэн бие даасан хоёр данс, тайлан тэнцэлтэй байгууллага мөн" гэж заасан нь улсын бүртгэлийн нэг гэрчилгээ, дүрэмтэй 2 байгууллага байхаар тусгасан байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйл Төрийн өмчийн талаарх засгийн газрын бүрэн эрх, 9 дүгээр зүйлийн 9.5 "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах эрхтэй байна", 15 дугаар зүйлийн 15.3 "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үдсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4 "үнэн зөв байх", 5.1.5 "хэмжигдэхүйц байх", 5.1.6 "зохицох" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу дүрэмд өөрчлөлт оруулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрэмт цамхаг УТҮГ-ын дарга, хурандаа Н.Мөнхжаргал, нягтлан бодогч Т.Чулуунцэнд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Г.ЭНХТӨР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig_Kherel\Yawsan_Bichig\2022\0315 Auditin 2 Газар-38.Docx

0010801049

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 30 lines.

